

## Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголт, хууль эрх зүйн мэдлэг

А. Солонго

УИС-ын ХАЗССТ-ийн

багш/судлаач

Сүүлийн жилүүдээс хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүд, хүүхдийн хүчирхийллийн асуудалд ихээхэн анхаарах болжээ. Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын үйл ажиллагааг энэ тал руу чиглүүлэх үүднээс ЭМНХЯ-ны "ЭХЭМ/ГБТ" төсөл, Либериааль эмэгтэйчүүдийн оюуны сан, Хүчирхийлэлийн эсрэг төв, Хуульч эмэгтэйчүүдийн холбоотой хамтран "Нөхөн үржихүйн эрүүл мэнд/хүчирхийлэл/хууль эрх зүйн мэдлэг" сэдэвт сургалтыг анх удаа 1997 оны 4 сард төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, хамтын ажиллагаа, төслийн хүрээнд Баянхонгор аймагт туршилтын журмаар явуулсан.

Энэхүү сургалтын цар хүрээ, ач холбогдол, үр дүнтэй байгаа эсэхийг түүвэр судалгаагаар шалган үнэлгээ шаардлага хангахуйц байж чадвал цаашид энэ чиглэлийн үйл ажиллагааг бусад аймаг, сумдад хэрэгжүүлэх юм.

Хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд/хүчирхийлэл/хууль эрх зүйн талаархи мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгааг сургалтаас өмнө 1997 оны 4-р сард Баянхонгор аймгийн Баянхонгор, Эрдэнэцогт, Галуут сумдад явуулсан бөгөөд товч үр дүнг та бүхэнд танилцуулья.

Сургалтаас өмнөх судалгаанд Баянхонгор аймгийн Баянхонгор, Эрдэнэцогт, Галуут сумдын 14-57 насны, эрэгтэй, эмэгтэй нийт 433 хүн хамрагдсны 96,3% нь нөхөн үржихүйн насны хүмүүс байв. Судалгаанд хамрагдагсдын 38.80% нь Баянхонгор, 38,87% нь Эрдэнэцогт, 23.32% нь Галуут суманд тус тус харьяалагдаж байна.

Хүснэгт 1.2: Сургалтын дараах судалгааны түүвэрлэлтийн нэгжийн хүрээ, Баянхонгор аймаг, 1997

Сонгосон сум	Судалгаанд хамрагдсан хүн ам		Судалгаанд хамрагдсан нөхөн үржихүйн насны хүн ам	
	тоо	хувь	тоо	хувь
Баянхонгор	168	53.22	164	97.6
Эрдэнэцогт	164	24.89	159	96.9
Галуут	101	21.89	94	93.7
<b>Бүгд</b>	<b>433</b>	<b>100.00</b>	<b>417</b>	<b>96.3</b>

### 1.1 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголт

Нийгэм, социологи, хүн ам зүйн судалгаа, хууль сахиулах ажилд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай ойлголт нэр томъёог цэгцэлж, илүү тодорхой болгон хэрэглэх, нийгмийн хурц асуудлын хувьд ил тод

гарган тавьж, таслан зогсоох талаар тэмцэл явуулж эхэлсэн нь бидний хувьд хүний эрхийн асуудалд оруулж буй томоохон ахиц дэвшил юм.

Судалгаанд хамрагдагсдаас –Та хүчирхийллийн асуудлыг юу гэж ойлгодог вэ? гэж асуусан бөгөөд үр дүнг хүснэгт 1.1.1-д үзүүлэв.

Ойлголт	Баянхонгор	Эрдэнэцогт	Галуут	Бүгд	Хар.тоо
Хүчин	17.26	39.63	44.55	32.10	139
Бие махбодид гэмтэл учруулах, зодох	20.83	14.02	6.93	15.01	65
Сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох	33.93	20.73	20.73	25.87	112
Эрх мэдэл, э/з-ийн давуу талаар дарамт үзүүлэх	18.45	14.63	8.91	14.78	64
Мэдэхгүй	9.52	10.98	18.81	12.24	53
<b>Хариулагчдын тоо</b>	<b>168</b>	<b>164</b>	<b>101</b>	<b>100.0</b>	<b>433</b>

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь хүчин (32.10%), сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох (25.87%) явдал гэж үздэг хүмүүс хамгийн өндөр хувьтай байна. Гэвч эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг мэдэхгүй гэж 12.24% нь хариулсан нь нэлээд өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь уг хариултыг өгсөн хэсэг дотор ийм явдал тохиолдол огт байдаггүй гэсэн үг хараахан биш болов уу.

Баянхонгор суманд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох явдал гэсэн хариулт өндөр хувьтай байхад Эрдэнэцогт, Галуут сумдад хүчин гэсэн хариулт өндөр байна. Мэдэхгүй гэсэн хариулт Галуут суманд хамгийн өндөр байна. Мэдэхгүй гэж хариулт өгсөн эмэгтэйчүүдийн 73.58% нь гэрлэсэн, 22.64% нь огт гэрлээгүй эмэгтэйчүүд байв.

Ойлголт	Гэрлээгүй	Гэрлэсэн	Тусгаарласан	Салсан	Бэлэсэн	Хамт амьдардаг	Бүгд
Хүчин	41.01	53.96	0.0	1.44	2.16	1.44	100.0
Бие махбодид гэмтэл учруулах, зодох	44.62	52.31	0.0	1.54	0.0	1.54	100.0
Сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох	17.86	71.43	0.89	0.0	1.79	8.04	100.0
Эрх мэдэл, э/з-ийн давуу талаар дарамт үзүүлэх	23.44	68.75	1.56	1.56	0.0	4.69	100.0
Мэдэхгүй	22.64	73.58	0.0	0.0	1.89	1.89	100.0

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголтыг гэрлэлтийн статусаар авч үзэхэд "хүчин" гэж хариулсан эмэгтэйчүүдийн 53.96% нь гэрлэсэн, "бие махбодид гэмтэл учруулах, зодох" гэж хариулсан эмэгтэйчүүдийн 52.31% нь гэрлэсэн, "сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар

доромжлох" гэж хариулсан эмэгтэйчүүдийн 71.43% нь гэрлэсэн, "эрх мэдэл, эдийн засгийн давуу байдлаар дарамт үзүүлэх" гэж хариулсан эмэгтэйчүүдийн 68.75% нь гэрлэсэн эмэгтэйчүүд байна. Эндээс гэрлэсэн буюу гэр бүлтэй эмэгтэйчүүд хүчирхийлэлд хамгийн их өртдөг болох нь харагдаж байна.

Хүснэгт 1.1.3 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, нөхөр/хосын боловсролын түвшингээр, Баянхонгор, 1997

Ойлголт	Боловсролгүй	Анхан шатны	Бүрэн бус дунд	Бүрэн дунд	Мэргэжлийн	Колл еж	Дээд	Бүгд
Хүчин	1.30	2.60	23.38	28.57	9.09	25.97	9.09	100.0
Бие махбодид гэмтэл учруулах, зодох	0.0	0.0	17.14	20.0	11.43	37.14	14.29	100.0
Сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох	1.12	0.0	17.98	32.58	11.24	23.60	13.48	100.0
Эрх мэдэл, э/з-ийн давуу талаар дарамт үзүүлэх	0.	2.13	14.89	21.28	6.38	25.53	29.79	100.0
Мэдэхгүй	0.0	5.0	12.50	20.0	10.0	32.50	20.0	100.0

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголтыг нөхөр/хосын боловсролын түвшингээр нь судалж үзсэн юм. Нөхөр/хос нь бүрэн дунд болон тусгай дунд боловсролтой эмэгтэйчүүдийн хувийн жин дээр дурьдсан бүх ойлголтууд дээр хамгийн өндөр байлаа. Харин эрх мэдэл, эдийн засгийн давуу талаар дарамт үзүүлэх гэж нөхөр/хос нь дээд боловсролтой эмэгтэйчүүд илүү үздэг юм байна.

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголтыг нөхөр/хосын ажил эрхлэлтийн байдлаар хүснэгт 1.1.4-д үзүүлэв.

Хүснэгт 1.1.4 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, нөхөр/хосын ажил эрхлэлтийн байдлаар, Баянхонгор, 1997

Ойлголт	Ажил эрхэлж буй	Ажил эрхлээгүй
Хүчин	44.16	55.84
Бие махбодид гэмтэл учруулах, зодох	34.29	65.71
Сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох	42.70	57.30
Эрх мэдэл, э/з-ийн давуу талаар дарамт үзүүлэх	51.06	48.94
Мэдэхгүй	47.50	52.50
Хариулагчдын тоо	127	161


Эрх мэдэл, эдийн засгийн давуу талаар дарамт үзүүлэх гэж хариулсан эмэгтэйчүүдээс бусад хариулагчдын нөхөр/хосын 55-аас дээш хувь нь тухайн хугацаанд ямар нэгэн ажил эрхлээгүй байна.

Хүснэгт 1.1.5 Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаарх ойлголт, төрүүлсэн хүүхдийн тоогоор, Баянхонгор, 1997					
Ойлголт	Төрүүлсэн хүүхдийн тоо				бүгд
	0	1-2	3-4	5+	
Хүчин	41.73	28.78	20.14	9.35	100.0
Бие махбодид гэмтэл учруулах, зодох	40.0	29.23	24.62	6.15	100.0
Сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох	19.64	44.64	28.57	7.14	100.0
Эрх мэдэл, э/з-ийн давуу талаар дарамт үзүүлэх	23.44	26.56	39.06	10.94	100.0
Мэдэхгүй	22.66	32.08	33.96	11.32	100.0
Хариулагчдын тоо	133	143	119	38	433

Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаархи ойлголтийг тэдний төрүүлсэн хүүхдийн тоогоор хүснэгт 1.1.5-д үзүүлэв. Огт хүүхэд төрүүлээгүй эмэгтэйчүүдийн дийлэнх нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хүчин, бие махбодид гэмтэл учруулах гэж үзэж байхад 1-4 хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь сэтгэл санаагаар дарамтлах, хэл амаар доромжлох гэж үзэж байна. Харин 5 ба түүнээс дээш хүүхэд төрүүлсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь эрх мэдэл, эдийн засгийн давуу талаар дарамт үзүүлэх гэж үзжээ. Эндээс гэр бүлийн доторхи эхнэр нөхрийн хоорондын харилцаа дахь хүчирхийлэл олон жилээр маш тогтвортой хадгалагдсаар байдгийг харуулж байна.

**1.2 Хууль, эрх зүйн талаархи эмэгтэйчүүдийн мэдлэг**

Сургалтаас өмнөх судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн 33 хүрэхгүй хувь нь "Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр", "Нөхөн үржихүйн эрх", "Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай Олон Улсын конвенц" -ийн талаар мэднэ гэжээ. Зарим хуулийн талаархи эмэгтэйчүүдийн мэдлэгийг зураг 4.1-д үзүүлэв.



Зарим хууль эрх зүйн талаар огт мэдлэггүй эмэгтэйчүүдийг сонгосон үзүүлэлтээр хүснэгт 1.2.1-д үзүүлэв. Мэдэхгүй гэж хариулт өгсөн эмэгтэйчүүд хөдөөгийн хоёр суманд тэр дундаа Галуут суманд нэлээд өндөр байна.

Хүснэгт 1.2.1 Зарим хуулийн талаар огт мэдлэггүй эмэгтэйчүүд, сонгосон үзүүлэлтээр, Баянхонгор, 1997			
Сонгосон үзүүлэлт	Гэр бүлийн хүчирхийлэлийн хэлбэр	Нөхөн үржихүйн эрх	ЭБТЯГЯУ тухай конвенц
<b>Сууршил</b>			
Баянхонгор	55.95	59.52	58.93
Эрдэнэцогт	69.51	85.37	70.12
Галуут	78.22	90.10	75.25
<b>Ажил эрхлэлт</b>			
Ажил эрхэлж буй	55.84	42.64	57.36
Ажил эрхлээгүй	75.0	25.00	75.00
Мэдлэггүй эмэг.тоо	287	331	290

ЭБТЯГЯУ –Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай конвенц

Үүнд Галуут сумаас авсан судалгааны дүн ихээхэн болгоомжлол төрүүлэхээр байна. Энд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар мэдэхгүй гэж их өндөр хувьтай хариулсан ба өөрсдийн эрхийн тухай мэдэхгүй, эрх зүйн мэдлэг багатай эмэгтэйчүүд энэ суманд мөн өндөр байгаа нь тэд өөрсдөө хүчирхийлэлд өртөж байдгаа мэддэггүй, эсвэл тэгж тооцдоггүй гэж үзэж болохоор байна. Энэ нь хүчирхийллээсээ дутахгүй эмгэнэлтэй үзэгдэл юм. Эндээс гарах арга зам бол нэн түрүүний эрх зүйн мэдлэг мэдээллийг хүртээмжтэй, хялбар замаар хүргэх явдал гэдэг нь хэнд ч ойлгомжтой.

Хууль эрх зүйн мэдлэггүй эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийн байдлыг авч үзэхэд ажил эрхэлж байгаа болон эрхлээгүй эмэгтэйчүүдийн аль алиных нь "Гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр", "Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай Олон Улсын конвенц" –ийн талаарх мэдлэг нэлээд доогуур байна. Эндээс албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, ажиллагсдынхаа ар гэр, сэтгэл санаа, эрх зүйн мэдлэгийн түвшинд анхаарал тавих явдал бага байгааг харуулж байна.

### 1.2-а. Нөхөн үржихүйн эрхийн талаархи ойлголт

Нөхөн үржихүйн эрхийн талаар нийт хариулагчдын 23.56% нь ямар нэгэн ойлголттой гэжээ. Хүснэгт 1.2.2- д нөхөн үржихүйн эрхийн талаархи ойлголт, мэдлэгтэй гэж хариулсан эмэгтэйчүүдийг сумдаар нь үзүүлэв. Тэдгээрийн талаас илүү нь нөхөн үржихүйн эрх гэдэг нь хэдэн хүүхэд төрүүлэхээ өөрөө шийдэх бололцоо гэж үзэж байна.

Хүснэгт 1.2.2 Нөхөн үржихүйн эрхийн талаархи ойлголт, сумдаар, Баянхонгор, 1997

Ойлголт	Баянхонгор	Эрдэнцогт	Галуут	Бүгд	Хариу. тоо
Олон хүүхэд төрүүлэх бололцоо	17.65	20.83	20.00	18.63	19
Хэдэн хүүхэд төрүүлэхээ өөрөө шийдэх бололцоо	57.35	45.83	50.00	53.92	55
Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой	17.65	25.00	10.00	18.63	19
Бусад	7.35	8.33	20.00	8.82	102
<b>Хариулагчдын тоо</b>	<b>68</b>	<b>24</b>	<b>10</b>	<b>100.0</b>	

**1.2-б "Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай" Олон Улсын конвенцийн талаарх мэдлэг**

"Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай" Олон Улсын конвенцийн талаар мэдлэгтэй эмэгтэйчүүдийн 4.90% нь энэ конвенцийг сайн судалсан, 69.93% нь уншиж байсан, 25.17% нь огт уншаагүй гэжээ. Эдгээр хариултыг сумдаар нь авч үзэхэд Галуут суманд энэхүү конвенцийг уншиж байсан гэсэн хариулт нэлээд доогуур, огт уншаагүй эмэгтэйчүүдийн түвшин өндөр байв.

Хүснэгт 1.2.3. Эмэгтэйчүүдийг бүх төрлөөр ялгаварлан гадуурхах явдлыг устгах тухай конвенцийг уншиж судалсан байдал, сууршлаар, Баянхонгор, 1997


Судалсан байдал	Баянхонгор	Эрдэнцогт	Галуут	Бүгд	Хар. тоо
Сайн судалсан	7.25	2.04	4.00	4.90	7
Уншиж байсан	79.71	67.35	48.00	69.93	100
Огт уншаагүй	13.04	30.61	48.00	25.17	36
<b>Хариулагчдын тоо</b>	<b>69</b>	<b>49</b>	<b>25</b>	<b>100.00</b>	<b>143</b>

**1.2-в Гэр бүлийн хүчирхийллийн талаархи ойлголт**

Гэр бүлийн хүчирхийлэл нь нийгэм эдийн засгийн болон Ази Дорно дахины орны хувьд Монголд түүхийн улбаатай нэг ёсны "уламжлалт" үзэгдэл бөгөөд маш далдлагдсан нууц хэлбэртэй байдаг нь сүүлийн үед тодорхой харагдах болжээ. Гэр бүлийн дарамтад байдаг эмэгтэй хүн эрүүл явах, нөхөн үржихүйн эрхээ эдлэх боломж муу байдаг гэдгийг та хүлээн зөвшөөрөх үү? гэж судалгаанд хамрагдсан нийт хүн амаас асууж сонирхсон юм. Хүснэгт 1.2.4-д энэ асуултын хариултыг хариулагчдын гэрлэлтийн статусаар нь үзүүлэв.


Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн хариултыг судалж үзвэл 87.30% нь хариу өгсөн байна. Хууль хэрэгтэй гэж хариулсан хариулагчдын 66.91% нь гэрлэсэн хариулагчдын 54.55% гэсэн хариултыг гаргажээ.

Хүснэгт 1.2.4. Гэр бүлийн дарамт эрүүл мэнд, нөхөн үржихүйн эрхэд нөлөөлөх нь										
		Гэрлэлтийн статус								
Үзүүдэлт		Гэрлээ гүй	Гэрлэсэн	Тусгаар ласан	Салсан	Бэлэвсэн	Хамт амьдар	Бүгд	Тоо	
Гэр бүлийн дарамт ЭМ/НҮ эрхэд нөлөөлдөг	Тийм	25.00	67.77	0.60	0.90	1.51	4.22	100.0	332	
	Үгүй	45.24	47.62	0.0	0.0	2.38	4.76	100.0	42	
	МГ	52.54	45.76	0.0	1.69	0.0	0.0	100.0	59	



Судалгаанд хамрагдсан нийт хүн амын 76.67% нь тийм, 9.70% нь үгүй, 13.63% нь мэдэхгүй гэж хариулжээ. *Тийм* гэж хариулсан эмэгтэйчүүдийн 67.77% нь гэрлэсэн, 25% нь огт гэрлээгүй, *үгүй* гэж хариулсан эмэгтэйчүүдийн 47.62% нь гэрлэсэн, 45.24% нь огт гэрлээгүй, мэдэхгүй гэж хариулсан эмэгтэйчүүдийн 52.54% нь огт гэрлээгүй эмэгтэйчүүд байна.

Судалгаагаар "Гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаад хэн буруутай вэ?" гэсэн асуултад мэдээлэл цуглуулсан юм. Хариултыг зураг 4.3-д дүрслэв.




Гэр бүлийн хүчирхийлэл гарахад 36.26% нөхөр эсвэл эхнэр, 24.71% нь нөхөр эхнэр хоёулаа, 17.55% нийгэм, 3% нь эцэг эх, хамаатан садан, цагдаагийн байгууллага буруутай гэж үзэж байна. Нийт хариулагчдын 18.4% нь мэдэхгүй гэж хариулсан бөгөөд тэдгээрийн дийлэнх нь гэрлэсэн болон огт гэрлээгүй хүмүүс байна.

Хүснэгт 1.2.5 Гэр бүлийн хүчирхийлэл гарч байгаад хэн буруутай вэ?

Үзүүлэлт	Гэрлэлтийн статус						Хамт амьдар	Бүгд
	Гэрлээгүй	Гэрлэсэн	Тусгаарласан	Салсан	Бэлтгэсэн	Бэлтгээгүй		
Нөхөр/эхнэр	37.58	57.32	0.0	0.64	1.91	2.55	100.0	
Эхнэр, нөхөр хоёулаа	23.36	67.29	0.93	1.87	2.80	3.74	100.0	
Эцэг эх/Хадам	20.0	60.0	0.0	20.0	0.0	0.0	100.0	
Хамаатан садан	14.29	57.14	0.0	0.0	0.0	28.57	100.0	
Цагдаагийн байгууллага	0.0	100.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	
Нийгэм	22.37	75.00	0.00	0.0	0.0	2.63	100.0	
МГ	37.50	56.25	1.25	0.0	0.0	5.0	100.0	
Хариулагчдын тоо	133	272	2	4	6	16		

Гэр бүлийн харьцааны талаар манайд хууль байдаг уу? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан нийт хүн амын 47.11% нь хууль байдаг, 41.57% мэдэхгүй, 11.32% нь байдаггүй гэж хариулжээ. Байдаг гэж хариулсан эмэгтэйчүүдийн дийлэнх нь (71.08%) гэрлэсэн эмэгтэйчүүд байхад мэдэхгүй гэж гэрлээгүй эмэгтэйчүүдийн 41.11% нь хариулсан байна.

Зураг 4.4 (а): Гэр бүлийн харьцааны талаар манайд хууль байдаг уу?  
Баянхонгор, 1997




Эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг биеэ даасан хууль шаардлагатай гэж 87.30% үзэж байхад 7.62% нь мэдэхгүй, 5.08% нь хэрэгтэй гэж үзсэн байна. Хууль хэрэгтэй гэж хариулсан эмэгтэйчүүд 66.93% нь гэрлэсэн хүмүүс байхад мэдэхгүй (66.6%) болон хэрэггүй (54.55%) гэсэн хариултыг гэрлээгүй хүмүүс илүү их өгчээ.

Хүснэгт 1.2.6 Гэр бүлийн харьцааны талаар манайд хууль байдаг болон эмэгтэйчүүдийн хүчирхийлэлийн эсрэг хууль шаардлагатай эсэх

Үзүүлэлт		Гэрлэлтийн статус							Тоо
		Гэрлээ гүй	Гэрлэсэн	Тусгаа рласан	Сал сан	Бэлэвсэн	Хамт амьдар	Бүгд	
Гэр бүлийн харьцааны талаар манайд хууль байдаг уу?	Тийм	22.06	71.08	0.98	1.96	1.96	1.96	100.0	204
	Үгүй	28.57	69.39	0.0	0.0	0.0	2.04	100.0	49
Эмэгтэйн хүчирхийлэлийн эсрэг бие даасан хууль шаардлагатай эсэх	Тийм	41.11	51.67	0.0	0.0	1.11	6.11	100.0	180
	Үгүй	26.19	66.93	0.53	1.06	1.59	3.70	100.0	378
	МГ	54.55	40.91	0.0	0.0	0.0	4.55	100.0	22
Хэн нэгний хүчирхийлэлд өртвөл өөрийгөө хамгаалах хууль эрх зүйн мэдлэг эзэмшэж чадсан эсэх	Тийм	66.67	30.30	0.0	0.0	0.0	3.03	100.0	33
	Үгүй	24.19	67.74	0.81	0.0	3.23	4.03	100.0	124
	Тийм	33.33	60.84	0.32	1.29	0.65	3.56	100.0	309
	Үгүй								

Судалгаанд хамрагдсан 71.36% нь хэн нэгний хүчирхийлэлд өртвөл өөрийгөө хамгаалах хууль эрх зүйн мэдлэг эзэмшиж чадаагүй гэжээ. Уг хариултыг өгсөн хүмүүсийн дийлэнх нь гэрлэсэн (60.84%) байна.

Зураг 4.4 (б): Эмэгтэйчүүдийн хүчирхийлэлийн эсрэг бие даасан хууль шаардлагатай эсэх



Судалгаанд хамрагдагсдын гэр бүлийн хүчирхийллийг бууруулах арга замыг сонгосон байдлыг хүснэгт 1.2.6-д үзүүлэв. Нийт хариулагчдын

талаас илүү хувь нь гэр бүлийн ухамсрыг дээшлүүлэх (30.25%), эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах (24.02%) нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах арга зам гэж хариулжээ.

Гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад гэр бүлийн гишүүдийн ухамсрыг дээшлүүлэх нь чухал гэж гэрлэсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь үзэж байхад тусгаарласан, салсан, бэлэвсэн эмэгтэйчүүдийн тал хувь нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулахыг чухалчилж байна. Харин огт гэрлээгүй эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь гэр бүлийн гишүүдийн ухамсрыг дээшлүүлэх (22.56%), эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулах (36.09%) хэрэгтэй гэж үзэж байна.

Хүснэгт 1.2.6 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах арга зам, сонгосон үзүүлэлтээр, Баянхонгор, 1997

Сонгосон үзүүлэлт	Гэр бүлийн гишүүдийн ухамсар	ОН сургалт	Хуулиа чангатгах	Эмэг. эдийн засгийн байдлыг сайж.лах	Архидал тыг буур.лах	Бусад	бүгд
<b>Гэрлэлтийн статус</b>							
Гэрлээгүй	22.56	12.03	12.78	36.09	66.77	9.77	100.0
Гэрлэсэн	33.82	18.01	15.07	18.01	9.56	5.51	100.0
Тусгаарласан	50.0	0.0	0.0	50.0	0.0	0.0	100.0
Салсан	0.0	25.0	0.0	50.0	0.0	25.0	100.0
Бэлэвсэн	0.0	16.67	0.0	50.0	33.33	0.0	100.0
Хамт амьдар.	50.0	31.25	0.0	6.25	12.50	0.0	100.0
<b>Боловсролын түвшин</b>							
Боловсролгүй	0.0	0.0	0.0	0.0	0.0	100.0	100.0
Анхан шатны	50.0	0.0	0.0	25.0	0.0	25.0	100.0
4-8-р анги	25.47	66.66	10.38	42.45	66.60	8.49	100.0
9-10-р анги	31.34	14.18	15.67	23.88	9.70	5.22	100.0
Мэргэжлийн	34.38	25.0	12.50	9.38	15.63	3.13	100.0
Тусгай/Коллеж	28.0	23.0	15.0	15.0	10.0	9.0	100.0
Дээд	37.50	26.79	12.50	14.29	7.14	1.79	100.0
<b>Ажил эрхлэлт</b>							
Ажил эрхэлж буй	37.06	18.78	14.72	14.21	10.66	4.57	100.0
Ажил эрхлээгүй	24.58	14.83	12.29	32.20	7.63	8.47	100.0
<b>Бүгд</b>	30.25	16.63	13.39	24.02	9.01	6.70	100.0
Хариу. тоо	131	72	58	104	39	29	433

Хариулагчдын боловсролын түвшингээр хариултуудыг авч үзэхэд боловсролын аль ч шатанд гэр бүлийн гишүүдийн ухамсрыг дээшлүүлэх хэрэгтэй гэсэн хариулт хамгийн өндөр хувьтай байна. Суурь боловсрол эзэмшсэн (8-10 жил) эмэгтэйчүүд эмэгтэйчүүдийн эдийн засгийн байдлыг сайжруулахыг, мэргэжлийн болон дээд, тусгай дунд боловсрол эзэмшсэн эмэгтэйчүүдийн олон нийтийн сургалтыг өрнүүлэх нь чухал арга зам гэж үзэж байгаа явдал мөн гэсэн хариулт өндөр хувьтай байна.

